



64

**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2020 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 33

Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт шаардлагатай нийт 13,725,000 /арван гурван сая долоон зуун хорин таван мянга/ төгрөгийн үнэтэй тоног төхөөрөмжийг хавсралтын дагуу бэлтгэж үндсэн хөрөнгөнд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга (Ц.Ганзориг)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай. Үүнд:

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2020 оны 4 дүгээр сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх;

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ) -д үүрэг болгосугай.

ДАРГА

С. СУХБААТАР

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 03 дугаар сарын
03.ний өдрийн 33 тогтоолын хавсралт

**Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын
Үндсэн хөрөнгөнд бүртгэх хөрөнгийн жагсаалт**

№	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Дэлгэц	ш	2	350,000	700,000
2	Дисанца	ш	1	350,000	350,000
3	Өнгөт хэвлэгч/Epson-L-1300	ш	1	1,750,000	1,750,000
4	Тог баригч	ш	4	230,000	920,000
5	Цаг бүртгэлийн төхөөрөмж/uf100/	ш	1	230,000	230,000
6	Хэвлэгч /хар/	ш	2	350,000	700,000
7	Камер/Вэб/	ш	4	90,000	360,000
8	Зөөврийн хард	ш	1	170,000	170,000
9	Төмөр хөлтэй эргэдэг сандал	ш	15	120,000	1,800,000
10	Дарга сандал	ш	1	680,000	680,000
11	Төмөр шкаф	ш	5	380,000	1,900,000
12	Сейф	ш	1	580,000	580,000
13	Суурин компьютер	ш	2	1,792,500	3,585,000
Нийт дүн					13,725,000 /арван гурван сая долоон зуун хорин таван мянга/